



**ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2023 оны 12 дугаар сарын 20

Дугаар 14/05

Баян-Өндөр сум

┌ Дүгнэлт өгөх, төлөвлөгөө батлах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/133 дугаар тушаалыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Иргэний зөвлөлийн 2023 онд хийсэн ажлыг 96 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсүгэй.

2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Иргэний зөвлөлийн 2024 онд хийх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3.Дээрх тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж, жилийн эцсийн тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг Иргэний зөвлөлийн дарга (Т.Батзориг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны  
12 дугаар сарын 20-ны өдрийн Ээлжит бус XIV  
хуралдааны 14/08 дүгээр тогтоолын хавсралт

**ОРХОН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДЭРГЭДЭХ ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
2024 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хийгдэх ажлууд	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтарч ажиллах байгууллага албан тушаалтан	Хүрэх үр дүн
1	2	3	4	5	6
<b>НЭГ.УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД</b>					
1.1	Холбогдох хууль дүрмийн дагуу зөвлөлийн ээлжит хуралдааныг зохион байгуулж хэрэгжүүлж буй үйл ажиллагаандаа үнэлэлт өгч цаашид хэрэгжүүлэх ажлын санал, мэдээлэл солилцох	Сар бүр		Зөвлөлийн гишүүд	Зөвлөлийн хурлыг тогтмол хугацаанд явуулж үйл ажиллагааг дүгнэдэг байх
1.2	Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдааныг зохион байгуулах	Тухай бүр		Зөвлөлийн гишүүд	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд ороогүй ч шаардлагатай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.
1.3	Иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанаар 2024 оны ажлын тайланг тавьж ажлаа дүгнүүлэх	12-р сард	Зөвлөлийн дарга, гишүүд	Аймгийн ИТХ-ын ажлын алба, Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хороо	Ажлаа дүгнүүлсэн байна.
1.4	Хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, үр дүнгийн талаар аймгийн ИТХ-ын даргад танилцуулах	Тухай бүр		Аймгийн ИТХ-ын хариуцсан ажилтан	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, ажлын албанд ажлынхаа талаар мэдээллээр хангасан байна.
1.5	Ажлын тайлан мэдээг хагас болон бүтэн жилээр гаргаж иргэд, олон нийтэд мэдээлэх	07-р сарын 10, дараа оны 01-р сарын 15-ны дотор		Аймгийн ИТХ-ын Ажлын алба	Иргэд олон нийтэд мэдээлж санал шүүмжлэл гарсан байх

1	2	3	4	5	6
1.6	Сонгон шалгаруулалтад тэнцэж аймгийн ИТХ-ын зөвлөлийн хурлаас томилогдсон гишүүдийг Цагдаагийн газрын удирдлага бие бүрэлдэхүүнд танилцуулж сургалтад хамруулах	07-р сард	Зөвлөлийн дарга	Аймгийн Цагдаагийн газрын дэд дарга, гишүүд	Ажлаа мэдэж авч хамтран ажиллах ажилтнуудтай танилцуулсан байна.
1.7	Цагдаагийн газрын тасаг албадын даргаар томилогдсон алба хаагчидтай уулзаж ажил сайжруулах талаар санал солилцож чиглэл өгөх	Тухай бүрд	Зөвлөлийн дарга, гишүүд	Аймгийн Цагдаагийн газрын дарга	Өмнөх удирдлагын үед яригдсан алдаа дутагдал засагдсан байна.
1.8	Шинээр томилогдсон гишүүдийг цагдаагийн хэсгийн байцаагч, эргүүлийн цагдаа, замын цагдаагийн зохицуулагчаар нэг өдөр ажиллуулж цагдаагийн ажлын онцлогтой танилцуулах	09-р сард	Зөвлөлийн дарга	Аймгийн Цагдаагийн газрын Нийтийн хэв журмын болон Замын цагдаагийн тасаг	Цагдаагийн ажлын мэдлэгтэй болсон байна.
<b>ХОЁРЦАГДААГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТ ТАВИХ ХҮРЭЭНД</b>					
2.1	Цагдаагийн газрын 2023 оны үйл ажиллагааны болон, санхүүгийн тайланг сонсож үнэлэлт дүгнэлт өгөх	01-р сарын 20-ны дотор	Зөвлөлийн дарга, гишүүд	Аймгийн Цагдаагийн газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын тасаг	Шаардлагатай санал гарч зөвлөмж өгсөн байх
2.2	Цагдаагийн алба хаагч, ажилтны гэмт хэрэг зөрчил үйлдсэн, сахилга ёс зүйн зөрчилд холбогдсон статистик мэдээллийг авч түүнд дүн шинжилгээ хийж зөвлөмж өгч ажиллах	Улирал тутамд	Хариуцсан зөвлөлийн гишүүн		Шаардлагатай санал зөвлөмж гарч өгөгдсөн байх
2.3	Цагдаагийн албан хаагчдын 2024 оны сургалтын төлөвлөгөө хөтөлбөртэй танилцаж тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	Жилдээ	Хариуцсан зөвлөлийн гишүүн		Шаардлагатай санал зөвлөмж
2.4	Аймгийн ИТХ-ын Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хороо, Цагдаагийн газрын удирдлага, ахлагч нарын зөвлөлтэй уулзаж тулгамдсан асуудлаар санал солилцох	Улирал тутам	Хариуцсан зөвлөлийн гишүүн		Шаардлагатай асуудлаар мэдээлэл солилцож, тулгамдаж буй зарим асуудлыг шийдвэрлэсэн байх

1	2	3	4	5	6
2.5	Цагдаагийн газарт иргэд аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан гэмт хэрэг, зөрчлийн талаарх өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх хуульд заасан хугацаанд шалгах, шийдвэрлэх, иргэний зөрчигдсэн эрхийг хангах үйл ажиллагаатай холбоотой тайлан мэдээ авч дүн шинжилгээ хийх	Улирал тутам	Хариуцсан зөвлөлийн гишүүн	Аймгийн Цагдаагийн газрын өргөдөл гомдол хариуцсан байцаагч	Шаардлагатай санал зөвлөмж гарч өгөгдсөн байх
2.6	Цагдаагийн албаны тухай хуулийн 7-р бүлэгт заасан эрхийн дагуу болон ХЗДХ-ийн сайдын А/133 -р тушаалаар баталсан иргэний зөвлөлийн дүрэм бусад хууль тогтоомжийн хүрээнд цагдаагийн байгууллагад хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, технологийн дэвшлийг хангуулж ажиллах	Жилдээ	Зөвлөлийн дарга гишүүд	Аймгийн ИТХ-ын дарга, Ажлын алба	Шаардлагатай санал зөвлөмж гарч өгөгдсөн байх
<b>ГУРАВ.ИРГЭДИЙН ЭРХ АШГИЙГ ХАНГАХ, ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b>					
3.1	Цагдаагийн газрын тайланг иргэдэд нээлттэй тайлагнаж утас болон цахимаар санал, хүсэлт хүлээн авч, түүний мөрөөр ажил зохион байгуулах	01-р сард		Аймгийн Цагдаагийн газрын зөвлөлийн гишүүд	Иргэдийн саналд тулгуурлан ажил зохион байгуулж хариу өгсөн байх
3.2	2023 онд гэмт хэрэг, зөрчил өссөн багуудыг ИНХ-д оролцож иргэдийн санал хүсэлтийг сонсож судалгаа хийн гэмт хэрэг зөрчил өссөн шалтгаан зөрчлийг арилгах талаар багийн засаг дарга цагдаагийн хэсгийн байцаагч нарт хургуулж хяналт тавьж ажиллах	04-р сард	Зөвлөлийн дарга, гишүүд	Баян-ендөр, Жаргалант сумдын ЗДТГ-ын дарга нар болон багийн Засаг дарга нар	Иргэдээс гарсан санал хүсэлтийг харгалзан ажил зохион байгуулагдсан байх
3.3	Орхон аймгийг хөгжүүлэх 5-н жилийн үндсэн чиглэл, засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөнд тусгагдсан амар тайван аюулгүй хот бүлгийн биелэлтийг гаргаж дүгнэлт хийх	Жилдээ		Цагдаагийн газрын Захиргаа удирдлагын тасаг	Ажлын хэрэгжилтийг гаргаж дүгнэлт өгөх

1	2	3		5	6
3.4	ИНХ, багуудын Засаг дарга, ахмадын зөвлөл, ТББ-ын удирдлагын уулзалт зөвлөгөөнд оролцож цаг үеийн асуудлаар мэдээлэл өгч байх	Сар бүр		Баян-өндөр, Жаргалант сумдын ЗДТГ	Харилцан мэдээлэл солилцсон байна
3.5	Аймаг, сумын ИТХ-ын Төлөөлөгчидтэй тухайн багт гарч буй гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой асуудлаар санал солилцох, хамтран ажиллах	Жилдээ		Аймаг, сумын ИТХ-ын Төлөөлөгчид	Харилцан санал солилцож, хамтран ажилласан байна
3.6	Өсвөр насны хүүхдүүдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн газар болон сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчидтэй хамтарсан уулзалт зохион байгуулж, мэдээлэл солилцон, ажлын уялдаа холбоог сайжруулах	Жилдээ		Аймгийн Цагдаагийн газар, ЕБС-ийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч	Уулзалт зохион байгуулан, мэдээлэл солилцож, хамтын ажиллагаа сайжирсан байна.
3.7	Аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл засаг даргын 2024-2027 онд хэрэгжүүлэх хөтөлбөр төлөвлөгөөнд санал өгөх	3, 4-р улиралд		Цагдаагийн газрын Захиргаа удирдлагын тасаг	Тодорхой асуудлыг төлөвлөгөөнд тусгах
3.8	70351111, 70391111 төвүүдээс мэдээлэл авч иргэдийн санал гомдлыг барагдуулах ажилд хяналт тавьж ажиллах	Жилдээ		Хариуцсан гишүүн	Санал гомдол хуулийн хүрээнд шийдвэрлэгдсэн байна.
<b>ДӨРӨВ.МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР</b>					
4.1	Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран багуудын ажлын алба, иргэдийн төлөөлөлд эрх зүйн сургалт зохион байгуулах	Улирал бүр		Баян-Жаргалант сумдын ГХУСАЗСЗ	Иргэдийн эрх зүйн боловсрол дээшилсэн байх
4.2	Цагдаагийн газраас "Нээлттэй хаалга"-ны өдөр зохион байгуулахад оролцож иргэдээс мэдээлэл авах, Иргэний зөвлөлийн ажлыг сурталчлах, мэдээллийн мөрөөр ажил зохион байгуулж санал зөвлөмж бичиж холбогдох газруудад хүргүүлэх	Тухай бүрд	Зөвлөлийн дарга, гишүүд	Аймгийн Цагдаагийн газар	Зөвлөлийн танилцуулга мэдээлэл хийгдэж, иргэдэд мэдээлэл хүргэсэн байх

1	2	3	5	6
4.3	Цагдаагийн газрын үйл ажиллагаа, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохиож байгаа ажил түүний онцлогийг иргэдэд сурталчлах	Жилдээ	Аймгийн Цагдаагийн газар	Зөвлөлийн танилцуулга мэдээлэл хийгдэж, иргэдэд мэдээлэл хүргэсэн байх
4.4	Иргэний зөвлөлийн танилцуулгыг шинэчилж төрийн үйлчилгээний нэгдсэн төвд байршуулах	2-р улиралд	Баян-өндөр Жаргалант сумдын ЗДТГ	Иргэний зөвлөл болон иргэдийн харилцаа дээшилсэн байх
4.5	Цагдаа сэтгүүлийн "Иргэний зөвлөл" буланд мэдээлэл байршуулах	Улирал бүр	Цагдаагийн ерөнхий газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба	Зөвлөлийн үйл ажиллагааны мэдээлэл нэмэгдсэн байна.
4.6	2023 оны ажлын тайланг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл цахим сүлжээнд байршуулах	01-р сард	Аймгийн ИТХ-ын хариуцсан ажилтан	Зөвлөлийн үйл ажиллагаа танилцуулга хийгдсэн байна.
4.7	Аймаг сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дараа оны төлөвлөгөөнд санал өгөх	4-р улиралд	Цагдаагийн газрын Захиргаа удирдлагын тасаг	Тодорхой асуудлыг төлөвлөгөөнд тусгуулсан байна.
4.8	Орон нутгийн телевизээр иргэний зөвлөлийн үйл ажиллагааг сурталчлах	Жилдээ	Аймгийн Цагдаагийн газар, Аймгийн ИТХ-ын Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хороо, Ажлын алба	Иргэд мэдээлэл авсан байна.
4.9	Бүсийн аймгуудын иргэний зөвлөлийн гишүүдийн сургалт зөвлөгөөн зохион байгуулах	5-р сард	Аймгийн ИТХ-ын хариуцсан ажилтан	Сургалт зөвлөгөөнөөс тодорхой шийдвэр гарч хэрэгжсэн байна.

**ТАВ.БУСАД ЧИГЛЭЛЭЭР**

5.1	2024оны аймгийн ИТХ-ын дарга, засаг даргад өгсөн саналаас хөтөлбөр төлөвлөгөөнд тусгагдсан эсэхийг холбогдох хэлтсээс тодруулж шаардлагатай асуудлыг дараа онд дахин төлөвлөж хүргүүлэх	4-р улиралд	Аймгийн Цагдаагийн газар	Зөвлөлийн дарга, гишүүд	Санал гарч хүргэгдсэн байх
-----	---	-------------	--------------------------	-------------------------	----------------------------

1	2	3	5	6
5.2	Сумдын болон аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн хуралд Иргэний зөвлөлөөс төлөөлөл оролцож мэдээлэл авч байх	Тухай бүр	Аймаг, сумдын ГХУСАЗС3-ийн дарга	Мэдээлэл солилцсон байх
5.3	Баян-өндөр, Жаргалант сумын ГХУСАЗС3-д зөвлөмж хүргүүлж биелэлтэд хяналт тавьж ажиллах	01-р сард	Баян-Өндөр, Жаргалант сумдын ГХУСАЗС3	Зөвлөмжөөр өгсөн ажлын үр дүн дээшилсэн байх
5.4	Иргэний зөвлөлийн төсөвт тулгуурлан ямар аян хөдөлгөөн өрнүүлж ажиллахаа шийдвэрлэж холбогдох удирдамж гарган хэрэгжүүлэх	01-р сард	Аймгийн Цагдаагийн газар	ГХУСА-д шинэ санаачилга гарч ажил зохион байгуулагдсан байна.
5.5	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын гэрээт цагдаагийн тасаг, Дотоодын цэргийн тусгай салбарын үйл ажиллагаатай танилцах	1-р улиралд	Аймгийн Цагдаагийн газрын удирдлага	Хамтарсан ажлын үр дүн дээшилнэ.
5.6	Иргэний зөвлөлийн өмнөх оны баримт бичиг архивлах	1-р улиралд	Зөвлөлийн гишүүд	Бичиг баримтыг архивласан байх
5.7	Иргэний зөвлөлийн гишүүдийн гэр бүл өдөрлөг зохион байгуулах	9-р сард	Аймгийн ИТХ-ын дарга, Ажлын алба	Харилцаа холбоо тогтоосон байна.